

## Үнийн санал авах тухай

Огноо: 2024.08.01

### Монгол Улс

**Төслийн нэр:** Ухаалаг Засаг – 2 төсөл

**Худалдан авалт:** Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв байгуулах/тавилга

**Зээлийн дугаар.:** 7090-MN

**Худалдан авалтын дугаар.:** MN-MDDC-406514-GO-RFQ-2.3.1.2

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн хүрээнд Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв байгуулах тоног төхөөрөмж худалдаж авах ажилд үнийн санал ирүүлэхийг урьж байна.

1. Ухаалаг Засаг-2 төслийн Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв байгуулах тавилга худалдаж авах үнийн санал авах баримт бичгийн “Үнийн хуваарь”-д жагсаасан Бараа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн үнийн саналаа ирүүлэхийг урьж байна.
2. Үнийн саналаа өгөгдсөн загварын дагуу бэлтгэн дараах хаягаар ирүүлнэ үү: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Самбуугийн гудамж, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Сити капитал оффис, 3-р давхар, 301 тоот өрөө, худалдан авалтын ахлах мэргэжилтэн Б.Золзаяа, И-мэйл: [zolzaya@smart.gov.mn](mailto:zolzaya@smart.gov.mn)
3. Санал болгож буй барааныхаа үнийн саналыг тухайн барааны техникийн болон хэрэглэгчийн гарын авлага, танилцуулга, зураг мэдээлэл бүхий хэвлэмэл материал (каталог)-ийн хамт, компанийнхаа нэр, хаяг болон бусад холбогдох мэдээллийн хавсарган ирүүлнэ.
4. Үнийн саналыг хүлээж авах эцсийн хугацаа **2024 оны 8 дугаар сарын 15-ний өдрийн 14:00 цаг** болно. (Улаанбаатарын цаг).
5. Үнийн саналыг Дэлхийн Банкны Зээлдэгч нарт зориулсан худалдан авах ажиллагааны журам, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА: Бараа, Ажил, Зөвлөх ба Зөвлөхийн бус үйлчилгээ (2020 оны 11 дүгээр сард шинэчилсэн)- ний журмын дагуу үнэлнэ.
6. Та үнийн саналаа дараах зааврын дагуу ирүүлэх ёстой бөгөөд Хавсралт 1 дэх нийлүүлэх нөхцөлд гарын үсгээ зурж баталгаажуулсан байх ёстой.
  - a) **ҮНЭ:** Үнийг зөвхөн Монгол төгрөгөөр ирүүлэх ба, үүнд хүргэлтийн зардал, суурилуулалтын зардал, орон нутгийн бусад татвар хураамжийг “Үнийн хуваарь”-д заасны дагуу оруулан тооцсон байна.
  - b) **САНАЛЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА:** Таны үнийн санал нь дээр дурдсан 4-р зүйлд заасан санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ёстой.
7. Дэлгэрэнгүй мэдээллийг: Б.Золзаяа, Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Утас: 51261268;
8. Тодруулга: Үнийн санал ирүүлэхтэй холбоотой аливаа тодруулгыг бичгээр ирүүлэх ба эцсийн хугацаанаас хуанлийн 3 хоногийн өмнө дээрх хаягаар ирүүлэх ёстой. Захиалагч нь тодруулга хүссэн аливаа хүсэлтэд дээр дурдсан үнийн санал ирүүлэх эцсийн хугацаанаас өмнө бичгээр хариу өгнө.

9. Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, 50,000 (тавин мянга) төгрөгийн хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгөөр төлсөнөөр тендерийн баримт бичгийг худалдан авч болно.

Төлбөрийн данс:

Дансны нэр: Ухаалаг Засаг-2 төсөл

Дансны дугаар: 101900011844

Банкны нэр: Төрийн сан